



49  
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/31

Өвт

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын Цагдаагийн тасагт суудлын авто машин нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Бат-Эрдэнэ-Засаг даргын Тамгын газрын дарга  
Гишүүд: Б.Ууганчимэг-Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер

Л.Балжиням-5 дугаар багийн Засаг дарга

Ч.Нандин-Эрдэнэ-Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Г.Цэрэндулам-Нийгмийн бодлогын мэргэжилтэн

2. Сонгон шалгаруулалтыг эрх бүхий байгууллагаас гаргасан хууль, заавар, журам, аргачлалын дагуу ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хариуцлагатай байх зарчимд тулгуурлан зохион байгуулахыг Үнэлгээний хороо дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Г.Цэрэндулам)-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.АМГАЛАН